

**ЦАГААН-ҮҮР СУМЫН СӨБ-ЫН 2025 ОНД АВАХ ТҮЛШНИЙ МОДНЫ
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ, БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ**

1.Түлшинд зориулж бэлтгэсэн модыг **2,1 м** хүртэл урттайгаар тайрсан байна. Хэрэглэгчид нийлүүлэх бөөрөнхий түлээнд байх өмхний хэмжээ түлшний модныхоо нийт хэмжээний 5% -иас хэтрэхгүй байна. Бэлтгэсэн түлээний бөөрөнхий модны гадаргуу дахь ярыг тайрч цэвэрлэсэн байна. Нэг машин түлээ 8м³ - ээс бага байж болохгүй.

2. Стандарт: Түлшний мод бэлтгэх техникийн шаардлага MNS5413:2011-н дагуу бэлтгэж нийлүүлнэ.

3. Бараа хүргэх газар: Цагаан-Үүр сумын СӨБ /Түлээний хашаанд/

БАРААНЫ ЖАГСААЛТ БА БАРАА НИЙЛҮҮЛЭЛТИЙН ХУВААРЬ

Нэр	Тодорхойлолт	Тоо ширхэг	Хэмжээ нэгж	ТШӨХ-д заасан барааг хүргэх эцсийн цэг	Инкотермийн нөхцөлийн дагуу тогтоосон бараа нийлүүлэх хугацаа		
					Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх эцсийн хугацаа	Нийлүүлэгчийн санал болгосон хугацаа
Түлээний мод	MNS 5413: 2011	580	м ³	Цагаан-Үүр сумын СӨБ	2025.02.01	2025.04.01	



ЭРХЛЭГЧ: *[Signature]* Н.СОЁЛ-ЭРДЭНЭ/

**ЦАГААН-ҮҮР СУМЫН СӨБ-ЫН 2025 ОНД АВАХ "ТҮЛШНИЙ
МОД" ХУДАЛДАН АВАХ БҮТЭЭГДЭХҮҮНИЙ НИЙТ ТӨСӨВТ ӨРТӨГ 29,000,000**

№	Материалын нэр	Хэмжих нэгж	Хэрэгцээт тоо хэмжээ	Нийт төсөвт өртөг
1	Түлээ	м ³	580	29,000,000

Тайлбар:

Дээрх хэмжээ нь жилийн туршид шаардлагатай хэрэгцээт хэмжээ бөгөөд үүнийг батлагдсан төсөв, хуваарийн дагуу санхүүжилтийг шилжүүлж, худалдан авалт хийнэ. Түлээ татах зардалд 1 машин /8м3/, хөрөөдөх, хагалах, хураах, хог ачих үнийг түлээний үнэнд оруулан тооцож ирүүлнэ.

ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ ДАРГА :
ҮНЭЛГЭЭНИЙ ХОРООНЫ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА :
ГИШҮҮН:

[Signatures]

/ Т.БЯМБАСҮРЭН /

/ Г.МЭРГЭНЦЭЦЭГ /

/ Э. ОНОН /

МОНГОЛ УЛСЫН СТАНДАРТЫН ДАГУУ:
Ангилалтын код.79.040

Түлшний мод : Техникийн шаардлага	MNS 5413: 2011
Firewood. Technical requirement	MNS 5413:2004-ийн оронд

Стандартчилал , Хэмжилзүйн Үндэсний Зөвлөлийн 2011 оны 01 дүгээр сарын 27-ны өдрийн 04 дүгээр тогтоолоор батлав.

Энэхүү стандартыг улсын бүртгэлд бүртгэсэн өдрөөс эхлэн хүчинтэй.

Энэ стандартын шаардлагыг заавал мөрдөнө.

1. Зорилго

Энэхүү стандарт нь түлшний зориулалтаар бэлтгэж хэрэглэх модны төрөл , түүнд тавих техникийн шаардлагыг тогтоож , түлээний модыг бэлтгэхэд зөвшөөрөл олгох , хэрэглээ болон тээвэрлэлтэд хяналт тавихад оршино.

2. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь түлшний зориулалтаар ашиглагдах шилмүүст ба навчит төрлийн модон түлээг бэлтгэх , хүлээн авах , хянаж шалгах , тээвэрлэхэд хамаарна.

3. Норматив ишлэл

Энэхүү стандартад дараах баримт бичгийг иш татсан бөгөөд энэ стандартад өөрчлөлт орсон тохиолдолд хамгийн сүүлийн албан ёсны материалаас иш татаж хэрэглэнэ.

- MNS 8966:2002 , Мод бэлтгэх аж үйлдвэр – Бүтээгдэхүүн – Нэр томъёо ба тодорхойлолт ,
- MNS 2379:2010 , Бөөрөнхий модон материалын эзлэхүүний хүрд ,
- MNS 126:2010 , Шилмүүст төрлийн бөөрөнхий модон материал ,
- MNS 170:2010 , Навчит төрлийн бөөрөнхий модон материал ,
- ГОСТ 3243:88 , Түлээ . Техникийн шаардлага .

4. Нэр , томъёо тодорхойлолт

Энэ стандартад хэрэглэсэн нэр томъёог дор дурдсан утгаар ойлгоно.

4.1 Түлшний мод

Өөрийн хэмжээ ба шинж чанараараа хэрэгцээний модны шаардлагад тохирохгүй , зөвхөн түлшинд ашиглаж болох өнгөний хувиралт , өмх , яр , гүн ан цавтай , чанарын хувьд бүтээгдэхүүн үйлдвэрлэх боломжгүй , бөөрөнхий буюу цуулж хагалсан , түлшний зориулалттай мод , модлогийг ,

5. Ангилал

Түлшний зориулалтаар ашиглах модыг дулаан ялгаруулах чадвараас нь хамааруулан модлогийн төрлөөр гурван бүлэгт хуваана:

- 1- Хус , шинэс , хайлаас
- 2- Нарс
- 3- Гацуур , хуш , жодоо , улиас , улиангар , бургас

Түлшний модыг төрлөөс нь хамааруулан дараах байдлаар ангилна:

- а. Нэг төрлийн
- б. холимог төрлийн

Нэг төрлийн түлшний модонд нэг төрлийн модноос дангаар бэлтгэснийг , холимог төрөлд бусад өөр төрлийн модноос хольж бэлтгэснийг тооцно.

6. Техникийн шаардлага

6.1 Түлшний модонд хүснэгтэд заасан дараах хэмжээг мөрдөнө.

д/д	Түлшний модыг бэлтгэх хэлбэр	Модны төрөл	Нарийн үзүүрийн голч , см	Түлшний модны урт , м
1	Уртаар	Шилмүүст ба навчит төрлийн мод	3-14	1,0

2	Хэрчим буюу цуулж хагалсан байдлаар	-“-	15-аас дээш	0,25, 0,3 , 0,5 , 0,75

ТАЙЛБАР 1: 15 см-ээс дээш голчтой хэрчмийг хоёроос дээш хуваан цуулж хагалсан байна. ТАЙЛБАР 2: Хэрэглэгчийн шаардлагаар дээр заасан хэмжээнээс богино хэмжээтэй бэлтгэн нийлүүлж болно. Энэ тохиолдолд хэлбэлзэл нь 0,05-аас +0,10 хүртэл байна.

6.2 Хэрэглээний шаардлагаас хамаарч түлшний мод нь дараах нэмэлт шаардлагыг хангасан байна.

6.2.1 Түлшний модыг товарлаг чанараар муу , хэрэглээний шаардлага хангаагүй бүх шилмүүст ба навчит төрлийн модноос ой цэвэрлэх зориулалтаар бэлтгэнэ.

6.2.2 Түлшний модны өмхрөөгүй модлогийн эзлэх хувь нягтаар хэмжсэн нэг шоометр багцын эзлэхүүний 80 %-иас доошгүй байвал зохино.

6.2.3 Түлшний модонд бүх төрлийн яр , гэмтэл согог болон цөмийн ба зуламын өмхийг тайрцын талбайн 65 %-д зөвшөөрнө.

6.2.4 Тайрцын талбайн 30-аас 60 % хүртэл өмхтэй түлээний тоо хэмжээ нь хүлээн авч байгаа нийт түлээний 20%-иас хэтэрч болохгүй.

6.2.5 Түлшний модны гадаргууд нунтгарсан өмх байхыг зөвшөөрөхгүй.

6.2.6 Түлшний модны уртын хэмжээнд 2 см-ийн хэлбэлзлэл байж болно. Хэрэв энэ хэлбэлзлэлд багтаж байвал уртын хэмжээний доод шатлалд , түлшний модны урт үүнээс дээш хэлбэлзлэлтэй байвал дээд шатлалд хамааруулан тооцно.

6.2.7 Түлшний мод холтостой ба холтосгүй байж болно. Мөчрөөс бүрэн цэвэрлэсэн байна.

6.2.8 Ургаа нойтон мод , түймэр , хортон шавж болон бусад гаднын нөлөөнд өртөж гэмтээд дахин сэргэн ургаж байгаа мод , түүнчлэн өсвөр мод , жодоо , хуш , гацуур , хайлаасыг дээд шатны байгууллагын тусгай зөвшөөрөлгүйгээр түлээнд бэлтгэж хэрэглэхийг хориглоно.

7. Түлшний модыг хүлээн авах

7.1 Түлшний модыг хэсгээр /бөөнөөр/ нь хүлээн авна.Стандартын шаардлагад тохирсоныг баталгаа болгосон баримттай янз бүрийн тоо хэмжээний түлшний модыг нэг багц гэж тооцно.

7.2 Баримт бичигт дараах зүйлийг тусгана. Үүнд:

- Бэлтгэн нийлүүлэгчийн нэр, хаяг
- Модны төрөл
- Тоо хэмжээ

7.3 Түлшний модыг сийрэг шоо метр, эзлэхүүнээр хэмжиж хүлээн авна.

8.Түлшний модыг хэмжиж тооцох

8.1 Өрж хураасан түлшний модны тоо хэмжээг /эзэлхүүн/ тодорхойлохдоо түүний өндөр, урт, өргөнийг хэмжин, үржүүлж гаргана.

8.2 Нягтын шоометрийг сийрэгт шилжүүлэхдээ:

- 5-24 см голчтой модыг 2,20

- 24-36 см голчтой модыг 1,83
- 38 см-ээс дээш голчтой модыг 1,43 гэсэн итгэлцүүрээр тус тус үржүүлж тооцно.

9. Түлшний модыг тээвэрлэх

9.1 Түлшний модыг зөвхөн ачааны зориулалтын тээврийн хэрэгслэлээр тээвэрлэх ба тээврийн төрөл бүрт үйлчлэх ачаа тээврийн дүрмийн дагуу ачиж тээвэрлэнэ.